



**ТӨВ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
XV ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2019 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 03

Зуунмод

┌ Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, ┐
байршил, зориулалт, тогтоох тухай

Аймгийн иргэдэд 2020 онд өмчлүүлэх газрын тухай аймгийн Засаг дарга Ж.Батжаргалын мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, уг асуудалд Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд Монгол улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “з”, 19 дүгээр зүйлийн 19.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2020 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, хэмжээ, байршилыг хавсралт ёсоор дэмжиж, Монгол Улсын Засгийн газарт уламжлан батлуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2.Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн “Нийслэлийг аймгийн төвтэй холбосон улсын чанартай авто замын дагуух газарт /сумын төвөөс бусад/” гэсэн 4 дэх заалтын үндэслэн иргэдийн гаргасан хүсэлтээр манай аймгийн Баянчандмань, Аргалант, Сэргэлэн, Эрдэнэ зэрэг сумдын нутагт авто замын дагуух газарт газар өмчлүүлэх ажил хийгдэж байгаа нь хот байгуулалт, хот төлөвлөлтийн зарчим, шаардлага, нөхцөлд нийцэхгүй байгаа тул уг асуудлыг судлан үзэж, эрчим хүч, холбоо зэрэг дэд бүтэцийн асуудал шийдвэрлэгдэж, суурьшлын бүс бий болсон нөхцөлд л иргэнд газар өмчлүүлж байхаар шийдвэр гаргуулах саналыг Засгийн газарт уламжилсугай.

3. Энэ тогтоол, бусад холбогдох материалыг Засгийн газарт хүргүүлж, шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг дарга /Ж.Батжаргал/-д даалгасугай.

4.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд үүрэг болгосугай.


ДАРГА ЦЭНХБАТ

0100003

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2019 оны 12 дугаар сарын 25-ний
өдрийн 15-р хуралдааны 03 дугаар
тогтоолын хавсралт

**2020 ОНЫ СУМЫН ТӨВ, СУУРИН, УЛСЫН
ЧАНАРТАЙ АВТО ЗАМЫН ДАГУУ ИРГЭДЭД
ӨМЧЛҮҮЛЭХ ГАЗРЫН ХЭМЖЭЭ, ИРГЭНИЙ ТОО**

д/д	Сумдууд	Шинээр өмчлүүлэх (сумын төв, суурин газарт)		Улсын чанартай авто зам дагуу өмчлүүлэх газар		Одоо эзэмшиж, ашиглаж байгаа газрын нийт хэмжээ		Нийт байршлын тоо	2020 оны өмчлүүлэх газрын хэмжээ	2020 онд газар өмчилж авах иргэдийн тоо
		газрын хэмжээ /га/	Иргэний тоо	газрын хэмжээ /га/	Иргэний тоо	газрын хэмжээ /га/	Иргэний тоо			
1	Алтанбулаг	231.8	516	2.8	40			8	234.6	556
2	Аргалант	95	430	34.02	486	5	10	14	134.02	926
3	Архуст	6.75	27	6.75	27			2	13.5	54
4	Батсүмбэр	71.5	377	9.03	129			7	80.53	506
5	Баян	8.2	118					1	8.2	118
6	Баяндэлгэр	12.68	85	2.73	39			4	15.41	124
7	Баянжаргалан	15.47	121					3	15.47	121
8	Баян-Өнжүүл	7	100	9.1	130			2	16.1	230
9	Баянхангай	31.44	138	12.39	177			8	43.83	315
10	Баянцагаан	2.52	36	2.24	32			4	4.76	68
11	Баянцогт	31.48	212					3	31.48	212
12	Баянчандмань	47.01	487	2.38	44	55	275	14	104.39	806
13	Борнуур	8.71	34	21	300			8	29.71	334
14	Бүрэн	6	50					5	6	50
15	Дэлгэрхаан	8.31	95					1	8.31	95
16	Жаргалант	58.04	381					2	58.04	381
17	Заамар	24.2	267					6	24.2	267
18	Зуунмод	5.45	109			13.15	295	8	18.6	404
19	Лүн	18.33	85	5.04	72			3	23.37	157
20	Мөнгөнморьт	71.7	239					3	71.7	239
21	Өндөрширээт	5.04	56	1.61	23			2	6.65	79
22	Сэргэлэн	29.25	327			1.96	28	12	31.21	355
23	Сүмбэр	10	100					1	10	100
24	Угтаал	1	50					1	1	50

25	Цээл	13.29	142					3	13.29	142
26	Эрдэнэ	62.66	534			4.62	66	11	67.28	600
27	Эрдэнэсант	5.51	68	6.44	92			4	11.95	160
Нийт дүн		888.3	5184	115.5	1591	79.73	674	140	1083.6	7449